

АВРАГЧ-ГАЛ СӨНӨӨГЧИЙН ХӨГЖҮҮЛЭХ СУРГАЛТЫГ БҮЛЭГ ХАМТ ОЛНЫ УУР АМЬСГАЛТАЙ ХАМААРУУЛАН СУДАЛСАН НЬ

ДХИС-ийн магистрант, ахмад Г.Даваадорж

Хураангуй. Аливаа сургалт, хөгжлийн хөтөлбөрүүд нь ажилтны гүйцэтгэлд сайнаар нөлөөлөөд зогсохгүй, тэдний хоорондын харилцаа, хөдөлмөрийн бүтээмжид эерэг нөлөө үзүүлдэг нь олон судалгааны үр дүнгээр батлагдсан байдаг. Хувь хүний өрсөлдөөн, санал зөрөх, зөрчилдөөн үүсэх нь хортой бөгөөд бүлгийн нэгдмэл байдал, хамтын ажиллагааг алдагдуулна гэж үздэг учраас Япон менежерүүдийн үндсэн зорилго нь юуны өмнө бүлгийн уур амьсгалыг төлөвшүүлэхэд оршдог.

Эдгээрээс үндэслэн үзэхэд аврагч-гал сөнөөгчийн хөгжүүлэх сургалтыг байгууллагын жилийн зорилго, зорилтууд, жилийн төлөвлөгөөтэй уялдуулан зохион байгуулахаас гадна тэрхүү ажлын үр дүн тухайн байгууллагын бүлэг хамт олны уур амьсгалд хэрхэн үр дүн үзүүлж байгааг үнэлэн тогтоох шаардлагатай байна.

Түлхүүр үг: аврагч-гал сөнөөгч, хөгжүүлэх сургалт, бүлэг хамт олны уур амьсгал

Сэдвийн судлагдсан байдлыг авч үзвэл: Доктор П.Цэдэв “Аврагчдын сэтгэл зүйн бэлтгэл, түүнд тавигдах шаардлага”, Т.Лхамжав “Гал унтраах сэтгэл зүйн бэлтгэл”, С.Баттөмөр “Аврагч-гал сөнөөгчдийн сэтгэл зүй, бие бялдар, ур чадварын бэлтгэлийн харилцаа хамаарал” болон Аврагч-гал сөнөөгчдийн мэдлэг чадвар, сургалтын асуудлыг доктор П.Цэдэв, Т.Соронзонболд, С.Баттөмөр нарын эрдэмтэн судлаачид судалж ном, гарын авлага гаргасан байна. 2016 онд Н.Адъяадорж Аврагч-гал сөнөөгчийн ой, хээрийн түймрийн унтраах мэдлэг чадварт хийсэн судалгаа, 2017 онд Э.Энхбат Аврагч-гал сөнөөгчийн ур чадвар дээр суурилсан сургалтыг сайжруулах нь, 2018 онд О.Оюунбилэг Аврагч-гал сөнөөгчийн сэтгэл зүй, сэргээн заслын тусламж үйлчилгээг сайжруулах нь, Х.Батцэцэг Аврагчийн сэтгэл зүйн бэлтгэлийг дээшлүүлэх арга зам.

Судалгааны ажлын зорилго: Хөгжүүлэх сургалтын онол арга зүй, аврагч-гал сөнөөгчдийн сургалтын онцлогийн судалгаанд тулгуурлан аврагч-гал сөнөөгчийн сургалтын өнөөгийн байдалд шинжилгээ хийж, түүнийг бүлэг хамт олны уур амьсгалтай холбон сайжруулах арга замыг тодорхойлоход оршино.

Судалгааны ажлын зорилт:

- Хөгжүүлэх сургалтын онол арга зүйг, судлах.
- Аврагч-гал сөнөөгчийн хөгжүүлэх сургалтын онцлогийг тодорхойлох.
- Аврагч-гал сөнөөгчийн хөгжүүлэх сургалтын өнөөгийн байдлыг шинжлэх.
- Аврагч-гал сөнөөгчийн бүлэг хамт олны уур амьсгалыг тодорхойлох
- Аврагч-гал сөнөөгчийн хөгжүүлэх сургалтыг бүлэг хамт олны уур амьсгалтай холбон сайжруулах арга замыг тодорхойлох.

Судалгааны объект: Аврагч-гал сөнөөгчийн хөгжүүлэх сургалт

Судлах зүйл: Аврагч-гал сөнөөгчийн хөгжүүлэх сургалт болон Бүлэг хамт олны уур амьсгалын хамаарал

Судалгааны арга зүй, аргачлал: Судалгаанд нийгэм, хүмүүнлэгийн судалгаанд ашигладаг анализ, синтез, судлах зүйлийн онцлогтой холбоотойгоор асуулга, баримт бичгийн шинжилгээ, ярилцлагын зэрэг тоон болон чанарын аргуудыг хослуулан хэрэглэсэн. Асуулга судалгааны мэдээллийг боловсруулахдаа SPSS 21.0 программ ашиглан дан болон харьцуулсан тоололт, хүчин зүйлийн хамаарлын шинжилгээг хийв.

Бүлэг, хамт олны уур амьсгалыг судлахдаа ОХУ-ын эрдэмтэн О.Немовагийн хамт олны бүлгийн нягтрал, нийгэм сэтгэл зүйн уур амьсгалыг судлах аргачлалын дагуу хийсэн. Аргачлал нь: Бүлгийн нэгдмэл байдлыг хадгалах хүсэл, нягтралын түвшин, харилцааны давтамж, нээлттэй байдал, зохион байгуулалттай байдал, мэдээлэлтэй байдал, хамт олны хариуцлагатай байдал гэсэн 7 бүлэг асуудлын хүрээнд бүлэг тус бүрийн чанарын утгыг илэрхийлэх 74 асуултыг 7 үзүүлэлтээр өөрийн үнэлгээгээр үнэлүүлдэг.

Орхон аймгийн гал түймэр унтраах, аврах 3 ангийн жишээн дээр авч үзнэ.

Сургалтын арга зүйн онол, үзэл баримтлал: Хүнийг хөгжүүлэн төлөвшүүлэх, боловсролын зорилго, агуулгыг хэрэгжүүлэхэд чиглэгдсэн багш, суралцагчдын хамтын үйл ажиллагааны эрэмбэлэгдсэн үйлийн нэгдлийг сургалтын арга гэнэ. Тус судалгаанд суралцахуйн онол, биоэкологийн онол, Абрахам Маслоугийн хэрэгцээний шатлалын онол, байгууллагын нийгэм соёлын орчны талаарх онолыг ашигласан бөгөөд байгууллагын соёл, хамт олны харилцааны талаарх онол, үзэл баримтлал, суралцагч байгууллагын суралцах үйл ажиллагааны тухай онол, үзэл баримтлалуудад сургалтыг хэрхэн тайлбарласныг авч үзлээ. Компаний амжилт бол хамт олны нэгдмэл хүчин зүтгэлийн үр дүн (ганц хүнээс үл хамаарна) гэж үздэг. Япон хүн бүр өөрийн баг, хамт олныхоо бүтээмж ба амжилтанд оруулж буй хувь нэмэр бол түүний өөрийнх нь хүртэх үр шимийг нэмэгдүүлнэ гэдэгт итгэдэг учраас хамт олныхоо сайн сайхны төлөө хүчин зүтгэнэ гэж Япон менежментийн систем үздэг.

Бие бүрэлдэхүүний хөгжүүлэх сургалт: Төв орон нутгийн онцгой байдлын газар, хэлтсийн гал түймэр унтраах, аврах анги, салааны бие бүрэлдэхүүн нь өөрийн албан тушаалын тусгай мэдлэгийг сайжруулах, гүнзгийрүүлэх ажлыг бие даан гүйцэтгэнэ. Мэдлэгээ системтэйгээр сайжруулан гүнзгийрүүлэхийн тулд энэ ажил хийгддэг. Гал түймэртэй тэмцэх удирдах байгууллагаас гал түймэр унтраах аврах анги чиг үүрэг хариуцсан албан хаагчид, бие бүрэлдэхүүнийг бие даан суралцуулах талаар шийдвэр гаргадаг. Бие даан суралцах зүйлийн агуулгыг жилийн сэдэвчилсэн төлөвлөгөөгөөр тодорхойлж анги, хэсгийн даргаар батлуулна. Бие бүрэлдэхүүний санал, хөтөлбөр эзэмшилтийн үр дүн, ажлын алдаа дутагдалд хүргэж болзошгүй мэдлэг, чадвар, дадлын дутмаг байдлыг нөхөх, мэргэжлийн цол зэрэг хүртэх шалгаруулалтад тавигдах мэргэжлийн бэлтгэл агуулга зэргийг харгалзан судалбал зохих асуудал, сурах бичгийн жагсаалт гаргана. Бие даан суралцах ажиллагаа гал түймэр унтраах аврах анги, хэсгийн даргын шууд хяналтад явагдах ёстой. Бие даан суралцахад:

- Эрх зүйн хэм хэмжээний баримт бичгүүдийг судлах
 - Төрөл бүрийн сургалтын материалын тэмдэглэл хөтлөх
 - Хууль, эдийн засаг, техникийн болон тусгай мэдлэгийн чиглэлийн шинэ ном сурах бичигтэй тогтмол танилцах
 - Дадал чадвараа бататгах зорилгоор төрөл бүрийн дасгал хийх, гүйцэтгэх зэрэг ажлыг багтаасан байна. (ДХИС, Гал түймэр унтраах үйл ажиллагааны удирдлага, 2021)
- Эдгээрийг ахлагч бүрэлдэхүүний хөгжүүлэх сургалт хэмээн авч үзлээ.

Аврагч-гал сөнөөгчийн хөгжүүлэх сургалтын өнөөгийн байдал /Орхон аймгийн ГТУА-х 68-р ангийн жишээн дээр/:

Эрх зүйн хэм хэмжээний баримт бичгүүдийг судлах: Жил бүр Онцгой байдлын ерөнхий газрын гүйцэтгэлийн төлөвлөгөө, Онцгой байдлын байгууллагын сургалт, бэлтгэлийн нэгдсэн төлөвлөгөөг Онцгой байдлын ерөнхий газрын даргын тушаалаар баталж, түүнийг нийслэл, аймгууд даган мөрдөж, түүнд нийцүүлэн төлөвлөгөөг баталдаг. Орхон аймгийн Онцгой байдлын газраас баталсан “Бие бүрэлдэхүүний сургалт, бэлтгэлийн

нэгдсэн төлөвлөгөө"-г 2021-2023 онуудаар нэгтгэснийг хавсралт №01-ээс үзнэ үү. Үүнээс эрх зүйн баримт бичгүүдийг судлах хэсгийг тусгайлан авч үзвэл:

Хүснэгт № 1. Орхон аймгийн Онцгой байдлын газрын ахлагчийн бүрэлдэхүүний эрх зүйн хичээлийн сэдэв

№	Хичээлийн нэр	Сургалт зохион байгуулсан цаг		
		2021	2022	2023
1.1	Хууль эрх зүй	7	15	7
1.2	Дүрэм журам, бусад эрх зүйн баримт бичиг	6	7	14
3.1	Цэргийн жагсаалын дүрэм	9	10	10
3.2	Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа	0	10	10
6.1	Жолоочийн дүрэм, журам	4	4	4
Нийт		26	46	45

Эх сурвалж: Орхон аймгийн Онцгой байдлын газар

Орхон аймгийн Онцгой байдлын албаны ахлагчийн бүрэлдэхүүн нь 2021 онд 26, 2022 онд 46, 2023 онд 45 цагийн хууль эрх зүйн хичээлийг үзэхээр төлөвлөн гүйцэтгэсэн байна. Алба хаагч бүр хичээлийн сэдэв бүрээр тэмдэглэл хөтлөн салаан захирагчаар шалгуулдаг. 2021 онд цэргийн жагсаалын дүрмийн хичээл хамгийн их буюу 9 цаг бол хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны хичээлийн сэдэв тус жилд тусгагдаагүй байна. 2022 онд хууль эрх зүйн хичээл хамгийн их буюу 15 цаг, жолоочийн дүрэм хамгийн бага 4 цагийн хичээлийг үзжээ. 2023 онд дүрэм журам, бусад эрх зүйн баримт бичгийн хичээлийг хамгийн их цагаар үзэхээр төлөвлөсөн бол жолоочийн дүрмийг бага цагаар төлөвлөсөн байна.

Хүснэгт.№ 2. Орхон аймгийн ОБГ-ын бие бүрэлдэхүүний сургалтын бүлэг сэдэв, цаг


Хичээлийн сэдэв	Сургалт зохион байгуулсан цаг					
	2021		2022		2023	
	Цаг	Хувь	Цаг	Хувь	Цаг	Хувь
Бие бүрэлдэхүүний хичээл	39	16%	64	28%	63	24%
Эрүүл мэнд-сэтгэл зүйн бэлтгэл	29	12%	31	14%	22	8%
Цэргийн хэрэг, жагсаалын бэлтгэл	9	4%	20	9%	20	8%
Биеийн тамирын бэлтгэл хичээл	8	3%	-	0%	-	0%
Гал сөнөөгчийн тусгай бэлтгэл	45	19%	-	0%	-	0%
Жолоочийн мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх	85	35%	85	38%	85	32%
Холбоо зарлан мэдээлэл, шуурхай удирдлагын оператор нарт мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх	25	10%	26	12%	75	28%
Нийт цаг	240	100%	226	100%	265	100%

Төрөл бүрийн сургалтын материалын тэмдэглэл хөтлөх: Орхон аймгийн Онцгой байдлын газрын ахлагчийн бие бүрэлдэхүүнд сургалтыг 2021 онд 7 бүлгийн 33 сэдэв хичээлийг орсон бол 2022 оноос биеийн тамирын бэлтгэл хичээл, гал сөнөөгчийн тусгай бэлтгэл хичээл гэсэн 2 бүлэг сэдэв хасагдаж 5 бүлгийн 26 сэдвээр сургалтыг ордог болсон. Нийт сургалтын сэдэв, цагийг хавсралт №01-т үзүүлэв.

Ахлагчийн бүрэлдэхүүн нь 2021-2022 онуудад нийт 7 бүлгийн 33 сэдвээр 466 цагийн хичээлийг үзэж тэмдэглэл хөтөлжээ. Хүснэгтээс харвал жолоочийн мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх хэмээх бүлэг нь нийт сургалтын цагийн 35%-ийг бүрдүүлжээ. Тус бүлэг нь дүрэм журам, Гал унтраах автомашин техник хэрэгсэл, Ус соруулагч /Мотопомп/, Хөдөлгүүрийн систем, Норматив арга техник, Замын хөдөлгөөний аюулгүй байдал, Хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагаа гэсэн сэдвүүдтэй бөгөөд жолооч, механикч нарыг хөгжүүлэх сургалт юм. 2022 болон 2023 онуудад ч мөн адил нийт сургалтын цагийн 38%, 32%-ийг эзэлж байна. 2021 оны сургалтын сэдвүүдийг хамгийн олон цагаар нь эрэмбэлбэл гал сөнөөгчийн тусгай бэлтгэл, бие бүрэлдэхүүний хичээл, эрүүл мэнд-сэтгэл зүйн бэлтгэл, холбоо зарлан мэдээлэл, шуурхай удирдлагын оператор нарт мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, цэргийн хэрэг, жагсаалын бэлтгэл, биеийн тамирын бэлтгэл хичээл гэсэн дараалалтай байна. 2023 онд бие бүрэлдэхүүний сургалт гэсэн бүлэг нь 9 сэдвийн хүрээнд 63 цагийн хичээлийг орохоор төлөвлөжээ.

ГТУА-х 68-р анги нь ахлагч бүрэлдэхүүний мэргэжил, албаны мэдлэг, чадвар, дадлыг нэмэгдүүлэх зорилгоор 2020 оноос хойш мэргэжлийн хичээлийг 72 удаа орж давхардсан тоогоор 1383 алба хаагч хамрагджээ.


Зураг № 1. ГТУА-х 68-р ангийн зохион байгуулсан мэргэжлийн сургалтын тоо, хамрагдсан алба хаагчдын тоо



Эх сурвалж: ГТУА-х 68-р ангийн шифрийн мэдээ

Зураг №2-т ГТУА-х 68-р ангийн ахлагчийн бүрэлдэхүүнд орсон албаны хичээлийн тоо, хамрагдсан алба хаагчдын тоог харуулав.

Зураг № 2. ГТУА-х 68-р ангийн албаны хичээлийн тоо, хамрагдагчдын тоо



Эх сурвалж: ГТУА-х 68-р ангийн шифрийн мэдээ


2020 оноос 2023 оны хооронд ГТУА-х 68-р ангийн албаны хичээлийг 61 удаа орж давхардсан тоогоор 1564 хүн хамрагджээ.

Хүснэгт № 3. Сургалт орж, тэмдэглэл хөтөлсөн номын жагсаалт, сургалтын цаг

 Θ_x

сурвалж: ГТУА-х 68-р ангийн сургалтын төлөвлөгөө


Зураг № 3. ГТУА-х 68-р ангийн өдөр тутмын дасгал сургуулилт хийсэн тоо, хамрагдагчдын тоо



70

Тус ангийн үйлчлэх хүрээ нь Орхон аймгийн Эрдэнэ, Дэнж, Уртын гол, Яргуйт, Баянтал баг бөгөөд эдгээр багуудын объектуудад салаа тус бүр тархалтын сургуулилтыг хийж гүйцэтгэдэг. Хавсралт №02-т ГТУА-х 68-р ангийн тархалтын сургуулилтын дэлгэрэнгүй мэдээллийг харууллаа.


Зураг №4. ГТУА-х 68-р ангийн үйлчлэх хүрээний барилга байгууламжийн гал түймрийн эрсдэлийн зэргийн ангилал



Эх сурвалж: ГТУА-х 68-р ангийн тайлан мэдээ

Монгол Улсын шадар сайдын 61 дүгээр тушаалаар баталсан “Барилга байгууламжийн гал түймрийн эрсдэлийн зэргийн ангилал”-ын дагуу тус гал унтраах, аврах ангийн үйлчлэх хүрээнд үйл ажиллагаа явуулдаг 48 аж ахуй нэгжүүдийг ангилбал 15% нь онц аюултай, 21% нь нэгдүгээр зэрэглэл, 21% нь хоёрдугаар зэрэглэл, 44% нь гуравдугаар зэргийн галт түймрийн эрсдэлтэй байна. Тархалтын сургуульд 2021 онд 806, 2022 онд нийт 899 хүмүүс хамрагджээ. Салаа бүр тухайн жилд тархалтын сургууль явуулах аж ахуй нэгжтэй ажиллах төлөвлөгөөг ангийн захирагчаар батлуулдаг. Төлөвлөгөөний дагуу тархалтын сургууль явагдаж дууссаны дараа илтгэх хуудас бичдэг бөгөөд гал түймэр унтраах норм хангасан эсэх талаар тайланд бичдэг. Ангийн тактикийн сургууль нь салааны тархалтын сургуультай харьцуулахад гал түймрийн эрсдэлийн зэрэг өндөртэй барилга, байгууламж дээр явагддаг. Доорх зурагт 2021, 2022 онуудад тактикийн сургуулилт явуулсан аж ахуй нэгжүүдийн барилга байгууламжийн эрсдэлийн зэргийн ангиллыг харууллаа.

Зураг № 5. Тактикийн сургуулилт явуулсан аж ахуй нэгжүүдийн барилга байгууламжийн гал түймрийн эрсдэлийн зэргийн ангилал



Эх сурвалж: ГТУА-х 68-р ангийн тайлан мэдээ

Тактикийн сургуулилт явуулсан 8 аж ахуй нэгжээс 7 нь нэгдүгээр зэрэглэлийн гал түймрийн эрсдэлтэй, 1 нь онц аюултай гал түймрийн эрсдэлтэй барилга байгууламжтай байна. 2021 онд 305, 2022 онд 365 хүн тус сургуулилтад хамрагджээ.

Аврагч-гал сөнөөгчийн бүлэг хамт олны уур амьсгалыг тодорхойлох:

Хөгжүүлэх сургалтыг зохион байгуулснаар ажилтан, алба хаагчдад байгууллага нь тэднийг хөгжүүлэн боловсруулах, өсөн дэвжихэд нь анхаарч байна гэсэн халуун дулаан мэдрэмжийг төрүүлэхийн зэрэгцээ бүлэг хамт олны уур амьсгалд эергээр нөлөөлж тэдний ажилдаа хандах хандлага, урам зориг, итгэл үнэмшлийг нэмэгдүүлдэг. Энэхүү судалгааг ОХУ-ын эрдэмтэн О.Немовагийн хамт олны бүлгийн нягтрал, нийгэм сэтгэл зүйн уур амьсгалыг судлах аргачлалын дагуу хийв. Бүлгийн нэгдмэл байдлыг хадгалах хүсэл, нягтралын түвшин, харилцааны давтамж, нээлттэй байдал, зохион байгуулалттай байдал, мэдээлэлтэй байдал, хамт олны хариуцлагатай байдал гэсэн 7 бүлэг асуудлын хүрээнд бүлэг тус бүрийн чанарын утгыг илэрхийлэх 74 асуултыг 7 үзүүлэлтээр өөрийн үнэлгээгээр үнэлүүлдэг. Боловсруулахдаа аргачлалын дагуу үзүүлэлт тус бүрээр хувь гарган, судалгаанд оролцсон нийт ажилтны тоонд хувааснаар 7 шкал бүхий үнэлгээгээр үнэлж, байгууллага тус бүрээр гаргалаа. Тус судалгаанд Орхон аймгийн Аврах-гал унтраах ангиудын ахлагчийн бүрэлдэхүүнийг хамруулж, үр дүнг SPSS-21.0 программаар боловсрууллаа. Асуулт тус бүрийг хэн ч дэмждэггүй-1, Бараг хэн ч дэмждэггүй-2, цөөнх нь дэмждэг-3, тал хувь нь дэмждэг-4, дийлэнх нь дэмждэг-5, бүгд дэмждэг-6 гэсэн оноогоор дүгнэсэн.

Асуулгад хамрагдсан ахлагчийн бүрэлдэхүүний хувь хүний мэдээллийн хэсгийг хүснэгтэд харууллаа.

Хүснэгт № 4. Судалгаанд хамрагдагчдын хувь хүний мэдээллийн хэсэг

ГТҮА-х 68-р анги									
Хүйс		Нас		Ажилласан жил		Цол		Ам бүл	
эм	15%	18-25	19%	1-3	23%	дэд ахлагч	23%	3	23%
эр	85%	26-30	31%	3-5	31%	ахлагч	35%	4	42%
Боловсрол		31-40	31%	6-10	4%	ахлах ахлагч	42%	5	23%
Бүрэн дунд	73%	41-50	19%	11-20	42%			6	4%
Дээд	27%							7	8%
ГТҮА-х 81-р анги									
Хүйс		Нас		Ажилласан жил		Цол		Ам бүл	
эм	26%	18-25	43%	1-3	35%	дэд ахлагч	35%	3	39%
эр	74%	26-30	22%	3-5	13%	ахлагч	26%	4	26%
Боловсрол		31-40	22%	6-10	17%	ахлах ахлагч	39%	5	17%

Бүрэн дунд	83%	41-50	13%	11-20	30%			6	13%
Дээд	17%			21-ээс дээш	4%			7	4%
ГТУА-х 56-р анги									
Хүйс		Нас		Ажилласан жил		Цол		Ам бүл	
эм	0%	18-25	31%	1-3	31%	дэд ахлагч	34%	1-2	9%
эр	100%	26-30	25%	3-5	19%	ахлагч	19%	3	13%
Боловсрол		31-40	44%	6-10	22%	ахлах ахлагч	47%	4	38%
Бүрэн дунд	91%			11-20	28%			5	25%
Дээд	9%							6-7	12%
								8	3%

ГТУА-х 68-р ангийн хувьд судалгаанд хамрагдагчдын 85% нь эрэгтэй, 15% нь эмэгтэй, 73% нь бүрэн дунд боловсролтой, 23% нь дээд боловсролтой, 19% нь 18-25 настай, 62% нь 26-40 настай, 19% нь 41-50 настай, 42% нь 11-20 жил ажиллаж байгаа, 31% нь 3-5 жил ажиллаж байгаа, 42% нь ахлах ахлагч цолтой алба хаагчид байна. ГТУА-х 81-р ангийн хувьд судалгаанд хамрагдагчдын 83% нь бүрэн дунд боловсролтой, 17% нь дээд боловсролтой, 43% нь 18-25 насны, 44% нь 26-40 насны, 13% нь 41-50 насны алба хаагчид, 35% нь 1-3 жил ажиллаж байгаа, 30% нь 11-20 жил ажиллаж байгаа бол 39% нь ахлах ахлагч цолтой, 35% нь дэд ахлагч цолтой харьцангуй залуу бүрэлдэхүүнтэй байна. ГТУА-х 56-р анги нь дуудлага хүлээн авагч нь шуурхай удирдлагын төвд харьяалагддаг тул 100% эрэгтэй, 91% нь бүрэн дунд боловсролтой, насны бүтцийн хувьд 44% нь 31-40, 31% нь 18-25 настай алба хаагчидтай, 31% нь 1-3 жил ажиллаж байгаа нь хамгийн их хувийг эзэлж байна. Ахлах ахлагч цолтой алба хаагч 47% байна.

Бүлгийн нэгдмэл байдлыг хадгалах хүсэл: Тус үзүүлэлт нь 10 асуулттай бөгөөд асуулт бүрийн оноог нэмж, нийт алба хаагчдын тоонд хувааж тооцлоо.

Хүснэгт № 5. Бүлгийн нэгдмэл байдлыг хадгалах хүслийг тодорхойлох асуулгын үр дүн /оноогоор, хувиар/

Бүлгийн нэгдмэл байдлыг хадгалах хүсэл											
ГТУА-х Анги	Хувь хүний амжилт, давуу шинж чанарыг нь	Манай хамт олон асуудлаа	Манай хамт олон хувийн сонирхлыг хамт олны	Хамт олны ашиг сонирхлыг	Манай хамт олон хамт олны дунд хүлээн	Би Хамт олондоо итгэдэг.	Бид Хамт олонд ашигтай	Би хамт олны дунд тогтсон	Бид Хамт олныг бугаргах аливаа зүйлд	Бид Хамт олны амжилтад анхаарал	Дундаж
	3.5	3.6	3.3	3.9	3.8	4.3	4.4	4.6	3.4	4.5	3.9

68	58%	60%	55%	65%	64%	72%	74%	76%	57%	76%	66%
81	3.6	4.7	3.5	4.9	4.6	5.4	5.1	5.2	3.9	5.1	4.6
	60%	78%	59%	81%	76%	91%	85%	87%	64%	85%	77%
56	3.2	3.9	3.2	4.0	3.9	4.4	4.3	4.6	3.8	4.4	4.0
	54%	65%	54%	66%	65%	73%	72%	76%	63%	73%	66%
	3.4	4.1	3.4	4.3	4.1	4.7	4.6	4.8	3.7	4.7	

ГТУА-х 68-р ангийн бүлгийн нэгдмэл байдлыг хадгалах хүсэл 3.9 оноо буюу 66% байна. Асуулт бүрийг дэлгэрүүлбэл, би хамт олны дунд тогтсон уламжлалыг дэмждэг, би хамт олны амжилтад анхаарал тавьдаг гэсэн асуултууд хамгийн өндөр буюу 76%-ийн үнэлгээг судалгаанд хамрагдагчид өгчээ. Би хамт олныг бутаргах аливаа зүйлд хүчтэй эсэргүүцэл үзүүлдэг гэсэн асуулт нь 57% буюу 3.4 оноо, манай хамт олон хувийн ашиг сонирхлыг нийтийн ашиг сонирхолд нийцүүлдэг гэсэн асуултыг 55%-аар үнэлсэн нь хамгийн бага үнэлгээг авчээ.

ГТУА-х 81-р ангийн үзүүлэлт 77% байгаа нь бусад гал унтраах, аврах ангиудаас 11% өндөр дүгнэгдсэн нь нэгдмэл байдлаа хадгалах хүсэл бусад ангиудаас өндөр байгааг харуулж байна. Би хамт олондоо итгэдэг гэсэн асуултыг 5.4 оноо буюу 91%-ийн үнэлгээг өгсөн нь тус ангийн хамт олон бие биедээ итгэдэг болохыг харуулж байна. Хамгийн бага оноогоор үнэлэгдсэн асуулга бол хамт олны амжилт, давуу шинж чанарыг нь дөвийлгөхийг шүүмжилдэг гэсэн нь 60%, манай хамт олон хувийн ашиг сонирхлыг нийтийн ашиг сонирхолд нийцүүлдэг гэж 59%-ийн үнэлгээг өгчээ.

ГТУА-х 56-р ангийн бүлгийн нэгдмэл байдлаа хадгалах хүсэл дунджаар 66% гарчээ. Тэдний хувьд хамт олны дунд тогтсон уламжлалыг дэмждэг гэж 76%-ийн үнэлгээг өгсөн нь хамгийн өндөр үнэлгээ байна. Хамгийн бага үнэлэгдсэн нь хувь хүний амжилт, давуу шинж чанарыг дөвийлгөхийг шүүмжилдэг, манай хамт олон хувийн ашиг сонирхлыг нийтийн ашиг сонирхолд нийцүүлдэг гэсэн асуултууд тус тус 54% байна.

Бүлгийн нягтралын түвшин: Бүлгийн нягтралын түвшнийг 10 асуулгаар, хариулт бүрийг 6 оноогоор дүгнэсэн.

Хүснэгт № 6. Нягтралын түвшнийг тодорхойлох асуулгын үр дүн /оноогоор, хувиар/

Нягтралын түвшин											
ГТУА-х Анги	Төсөөтэй үзэл бололтой	Хамт олонд тулгарсан асууллын	Чөлөөт цагаа хамт өнгөрүүллэг.	Ажил үүргийн хуваарилалтад	Хамт олны сонирхлын үнэлгээ	Хамт олныхоо алдаа дутаглыг алихан	Ёс зүйн хэм хэмжээний талаар	Бие хүний болон нийгмийн давуу	Материаллаг урамшууллын	Шийтгэлд авсан арга хэмжээнд үнэлгээ	Дундаж
68	3.58	4.08	3.54	3.81	3.62	3.88	4.04	3.92	3.69	3.62	3.78
	60%	68%	59%	63%	60%	65%	67%	65%	62%	60%	63%
81	4.57	5.09	4.70	4.91	4.87	4.91	5.00	4.87	4.74	4.61	4.83
	76%	85%	78%	82%	81%	82%	83%	81%	79%	77%	80%
56	4.00	4.23	4.00	4.15	4.12	4.19	4.19	3.92	3.73	3.77	4.03
	67%	71%	67%	69%	69%	70%	70%	65%	62%	63%	67%

	4.0	4.5	4.1	4.3	4.2	4.3	4.4	4.2	4.1	4.0	
	67%	74%	68%	72%	70%	72%	74%	71%	68%	67%	

Нягтралын түвшин хамгийн өндөр нь ГТУА-х 81-р анги бөгөөд 4.83 оноо буюу 80% байгаа бол үүний дараа ГТУА-х 56-р анги 4.03 оноо буюу 67%, хамгийн бага дүгнэгдсэн нь ГТУА-х 68-р анги 3.78 оноо буюу 63%-аар алба хаагчид дүгнэжээ. Хамт олонд тулгарсан асуудлын талаарх нэгдмэл байр суурьтай гэсэн асуулга ГТУА-а 68-р ангид хамгийн өндөр үнэлгээ буюу 68% байгаа бол төсөөтэй үзэл бодолтой, хамт олны сонирхлын үнэлгээ нь төсөөтэй, шийтгэлд авсан арга хэмжээнд үнэлгээ ижил гэсэн асуулгууд хамгийн бага буюу 60%-ийн үнэлгээгээр алба хаагчид дүгнэжээ. ГТУА-х 81-р ангийн нягтралын түвшин 80% байгаа нь бусад ангиудаас 17% өндөр байна. Тус анги нь хамт олонд тулгарсан асуудлын талаарх нэгдмэл байр суурьтай гэсэн асуулгад хамгийн өндөр буюу 85% үнэлгээг өгчээ. Төсөөтэй үзэл бодолтой гэсэн асуулгыг хамгийн бага буюу 76%-аар үнэлжээ. ГТУА-х 56-р ангийн хамгийн өндөр буюу 71%-аар үнэлэгдсэн асуулга нь хамт олонд тулгарсан асуудлын талаарх нэгдмэл байр суурьтай гэжээ. Тус ангийн хамгийн багаар үнэлэгдсэн асуулга бол материаллаг хуваарилалтын зөв байдлын талаар тэгш үнэлдэг гэж 62%-ийн үнэлгээг алба хаагчид өгчээ.

Харилцааны давтамжийг 10 асуулгаар, хариулт тус бүрийг 6 оноогоор дүгнэлээ.

Хүснэгт № 7. Харилцааны давтамжийг тодорхойлох асуулга /оноогоор, хувиар/

Харилцааны давтамж											
ГТУА-х Анги	Бие биенийхээ амжилтаар	Бие биендээ итгэлэг	Бие биенийгээ хамгаалдаг	Бие биендээ тусалдаг	Хамт олны амжилтгүй	Бусдын онцлогт тохируулах	Бие биетэйгээ эелдэг	Бие биесээ хүндэлдэг	Хүнд үед нь биесээ лэмжлэг	Бие биетэйгээ нээлттэй	Дундаж
68	4.57	4.18	4.36	4.50	3.89	4.11	4.46	4.12	4.38	4.46	4.30
	76%	70%	73%	75%	65%	68%	74%	69%	73%	74%	72%
81	5.16	5.08	5.28	5.42	4.64	4.08	5.13	4.18	4.39	4.52	4.79
	86%	85%	88%	90%	77%	68%	85%	70%	73%	75%	80%
56	4.54	4.31	4.46	4.35	4.08	3.92	4.12	4.11	4.31	4.29	4.25
	76%	72%	74%	72%	68%	65%	69%	69%	72%	72%	71%
	4.8	4.5	4.7	4.8	4.2	4.0	4.6	4.1	4.4	4.4	
	79%	75%	78%	79%	70%	67%	76%	69%	73%	74%	

Харилцааны давтамжийг гал унтраах ангиудыг харьцуулж үзвэл ГТУА-х 81-р анги хамгийн өндөр 80%-ийн үнэлгээг авсан бол ГТУА-х 68-р анги 72%, ГТУА-х 56-р анги 71%-ийн үнэлгээг алба хаагчдаас авчээ. ГТУА-х 68-р анги бие биенийхээ амжилтаар бахархдаг гэж 76%-ийн үнэлгээг өгсөн нь хамгийн өндөр бол хамт олны амжилтгүй байдалд чин сэтгэлээсээ харамсдаг гэж 65%-ийн үнэлгээг өгсөн нь хамгийн багаар дүгнэгджээ. ГТУА-х 81-р анги бие биенийгээ хамгаалдаг байдал нь 88% байгаа бол бие биедээ тусалдаг байдал нь 90% байгаа нь хамгийн өндөр үзүүлэлт болжээ. Бусдын онцлогт тохируулан харьцдаг байдал нь 68% байгаа нь харилцааны чадвараа сайжруулах хэрэгтэйг харуулж байна. ГТУА-х 56-р ангийн бие биенийхээ амжилтаар бахархдаг байдал 76% гарсан нь хамгийн өндөр бол бусдын онцлогт тохируулан харьцдаг чанар 65% гарсан нь хамгийн бага байна.

Нээлттэй байдал: Албан хаагчид нээлттэй байх нь хоорондоо ойлголцоход хялбар болгодог. Бүлгийн нээлттэй байдлыг 10 асуулгаар, хариулт бүрийг 6 оноогоор дүгнэлээ.

Хүснэгт № 8. Хамт олны нээлттэй байдлыг тодорхойлох асуулга /хувиар, оноогоор/

Нээлттэй байдал											
ГТУА-х Анги	Бие биенийхээ амжилтаар бахархлаг	Бусад салаа хамт олон болон шинээр орсон алба	Бусад салаа хамт олны болон шинээр орж ирсэн алба	Хуучин шинэ алба хаагч өөр салааны алба хаагчид	Шинэ болон хуучин алба хаагчийг болигтоо үнэллэг	Бусад салаа хамт олны өмнө болон шинээр ирсэн алба	Бие биетэйгээ эелдэг харилцаатай	Бусад салааны хамт олон болон шинээр ирж буй алба	Бусад салаа хамт олон болон шинээр ирсэн алба хаагчдын	Бусад алба хаагч болон шинээр ирсэн алба хаагчийн	Дундаж
68	4.57	4.18	4.42	4.18	4.29	4.34	4.53	4.29	4.24	4.08	4.31
	76%	70%	74%	70%	71%	72%	75%	71%	71%	68%	72%
81	5.16	5.04	5.00	5.08	5.00	5.00	5.28	5.16	5.02	5.04	5.08
	86%	84%	83%	85%	83%	83%	88%	86%	84%	84%	85%
56	4.54	4.00	4.08	4.42	4.04	4.19	4.31	4.23	4.27	4.35	4.24
	76%	67%	68%	74%	67%	70%	72%	71%	71%	72%	71%
	4.8	4.4	4.5	4.6	4.4	4.5	4.7	4.6	4.5	4.5	
	79%	73%	75%	76%	74%	75%	78%	76%	75%	75%	

Дундаж үнэлгээгээр авч үзвэл ГТУА-х 81-р ангийн нээлттэй байдал 85% байгаа нь бусад ангиудаас 19%-аар илүү байна. Энэ нь тус ангийн алба хаагчид харьцангуй нээлттэй гэсэн үг юм. ГТУА-х 68-р ангийн бие биенийхээ амжилтаар бахархдаг байдал нь 76% буюу хамгийн өндөр байгаа бол бусад албан хаагч болон шинээр ирсэн алба хаагчийн амжилтгүй үйлдлийг чин сэтгэлээсээ хуваалцаж ойлгодог байдал 68% байгаа нь хамгийн бага үзүүлэлт байлаа. ГТУА-х 81-р ангийн бүх асуулга 80%-аас дээш дүгнэгдсэн нь харьцангуй нээлттэй байгааг харуулж байна. ГТУА-х 56-р анги бие биенийхээ амжилтаар бахархдаг бол шинэ болон хувийн албан хаагчийг бодитоор үнэлэхдээ анхаарах хэрэгтэйг харуулжээ.

Зохион байгуулалттай байдал: Онцгой байдлын алба хаагчийн хувьд ажлын онцлогоос хамаараад зохион байгуулалттай байх нь тун чухал байдаг. Тус шинж чанарыг тодорхойлохдоо 10 асуулт бүрийн хариултыг 6 оноогоор дүгнэлээ.

Хүснэгт № 9. Бүлгийн зохион байгуулалттай байдлыг тодорхойлох асуулга /оноогоор, хувиар/

Зохион байгуулалттай байдал											
ГТУА-х Анги	Бие биенийхээ амжилтаар бахархлаг	Ямар нэгэн маргаан зөрчилгүй ажил үүргээ	Бие биенийхээ ажлыг лэмжлэг	Ажлын дутагдлыг бие даан илрүүлж	Хамт олонд тулгарсан маргаан зөрчилтэй	Бие биетэйгээ богино хугацаанд харилцан	Шаардлагатай бол хамт олныг удирдан зохион	Шаардлагатай бол бусдынхаа өмнөөс ажил	Хүнд нөхцөлд нэгдмэл зохион байгуулалттай	Ажил үүргийн хуваарилалтыг богино	Дундаж
68	4.57	4.07	4.32	4.36	4.39	4.36	4.39	4.25	4.04	4.46	4.32

	76%	68%	72%	73%	73%	73%	73%	71%	67%	74%	72%
81	5.16	5.00	5.13	5.00	5.00	5.12	4.88	5.04	5.16	5.04	5.05
	86%	83%	85%	83%	83%	85%	81%	84%	86%	84%	84%
56	4.54	4.23	4.62	4.27	4.23	4.35	4.31	4.27	4.27	4.19	4.33
	76%	71%	77%	71%	71%	72%	72%	71%	71%	70%	72%
	4.8	4.4	4.7	4.5	4.5	4.6	4.5	4.5	4.5	4.6	
	79%	74%	78%	76%	76%	77%	75%	75%	75%	76%	

Бүлгийн зохион байгуулттай байдлыг авч үзвэл ГТУА-х 81-р анги 5.05 оноо буюу 84% байгаа нь бусад ангиудтай харьцуулахад зохион байгуулалт сайтай байгаа нь харагдаж байна. ГТУА-х 68 болон ГТУА-х 56-р анги нь тус тус 72% байгаа нь зохион байгуулалтаа сайжруулахад анхаарах хэрэгтэйг харуулж байна. ГТУА-х 68-р анги нь хүнд нөхцөл байдалд нэгдмэл зохион байгуулттай байх тал дээр ажиллаж сайжруулах хэрэгтэй бол ГТУА-х 56-р анги ажил үүргийн хуваарилалтыг богино хугацаанд хийдэг талыг анхаарч сайжруулах хэрэгтэй байна. ГТУА-х 56 болон ГТУА-х 68-р ангиудын хамгийн өндөр үзүүлэлт /77%, 76%/ нь ГТУА-х 81-р ангийн хамгийн бага /81%/ үзүүлэлтээс 4 хувь бага байгааг анхаарах хэрэгтэй.

Мэдээлэлтэй байдал: Хамт олон бие биенийхээ талаар болон ажил үүргийн хуваарилалт, хариуцлага, амжилт, сургамжийн талаар мэддэг нь хамт олны уур амьсгал сайжрах, ажил үүргийг хуваарилах, гүйцэтгэх, ажлын алдаа дутагдалгүй байх зэрэгт сайн нөлөөтэй.

Хүснэгт № 10. Бүлгийн мэдээлэлтэй байдлыг тодорхойлох асуулга /оноогоор, хувиар/

Мэдээлэлтэй байдал											
ГТУА-х Анги	Бие биенийхээ амжилтаар	Хамт олныхоо ажлын үр дүнг	Хамт олныхоо ажлын эерэг	Хамт олны дундах зан байдлын хэм	Өөрийн үүрэг хариуцлагаа сайн	Хамтран ажиллах арга замуудаа	Бусдынхаа ажлыг сайн мэдлэг	Бие биенийхээ ааш араншинг	Бие биенийхээ зуршил болон	Бие биенийхээ ажил байдлыг	Дундаж
68	4.57	4.50	4.12	4.27	4.65	4.50	4.42	4.65	4.38	4.50	4.46
	76%	75%	69%	71%	78%	75%	74%	78%	73%	75%	74%
81	5.16	5.04	4.88	4.81	5.04	4.81	5.00	4.81	4.77	4.81	4.91
	86%	84%	81%	80%	84%	80%	83%	80%	79%	80%	82%
56	4.54	4.61	4.48	4.58	4.76	4.67	4.70	4.67	4.64	4.67	4.63
	76%	77%	75%	76%	79%	78%	78%	78%	77%	78%	77%
	4.8	4.7	4.5	4.6	4.8	4.7	4.7	4.7	4.6	4.7	
	79%	79%	75%	76%	80%	78%	78%	78%	77%	78%	

Бүлгийн мэдээлэлтэй байдлыг авч үзвэл ГТУА-х 81-р анги 82%, ГТУА-х 56-р анги 77%, ГТУА-х 68-р анги 74% гарчээ. ГТУА-х 68-р ангийн хувьд өөр өөрийн үүрэг хариуцлагыг сайн мэддэг /78%/, харилцан ажиллах арга замуудаа мэддэг /75%/ бол, хамт олныхоо ажлын эерэг болон сөрөг талыг мэддэг байдал дээр ажиллаж сайжруулах хэрэгтэй байна. ГТУА-х 81-р анги нь бие биенийхээ зуршил болон онцлогийг мэдэх тал дээр анхаарах хэрэгтэй бөгөөд бусад үзүүлэлтүүд 80%-аас дээш байгаа нь сайшаалтай. ГТУА-х 56-р анги нь өөрийн үүрэг хариуцлагаа сайн мэддэг /79%/, хамтран ажиллах арга барилаа

сайн мэддэг /78%/, бусдынхаа ажлыг дэмждэг /78%/, бие биенийхээ ааш араншинг сайн мэддэг /78%/, бие биенийхээ ажил байдал ямар байгааг мэддэг /78%/ бол хамт олныхоо эерэг болон сөрөг талыг мэддэг /76%/ байгаа нь хамгийн бага үзүүлэлт болжээ. Тус ангийн хувьд бие биенийхээ талаар сайтар мэддэг болох талаар анхаарах хэрэгтэй. Энэ нь тус хамт олны 50% нь 1-5 жил ажиллаж байгаатай холбоотой байж болох юм.


Хамт олны хариуцлагатай байдал: Хамт олны хариуцлагатай байдал нь Онцгой байдлын албаны алба хаагчид нэн тэргүүнд байх шинж чанар юм. Тус шинжийг тодорхойлохдоо 10 асуулгыг хэрэглэлээ.

Хамт олны хариуцлагатай байдал											
ГТУА-х Анги	Бие биенийхээ амжилтаар	Бие биендээ шаардлага тавьдаг	Өөрийн амжилттай болон амжилтгүй	Асуудлыг шийдэхдээ	Эхэлсэн ажлыг дуусгах	Сайн ажилтай байхыг	Нийтийн ашиг сонирхлыг хувийн ашиг сонирхлыг	Компаний өмчид өөриймсөг ханлаг	Ямар ч ажлыг хариуцлагатай	Нийгмийн ажилд илэвхтэй оролцог	Дундаж
68	4.57	2.63	2.62	2.65	2.59	2.58	2.67	2.59	2.57	2.58	2.81
	76%	44%	44%	44%	43%	43%	45%	43%	43%	43%	47%
81	5.16	2.63	2.62	2.65	2.59	2.58	2.67	2.59	2.57	2.58	2.86
	86%	44%	44%	44%	43%	43%	45%	43%	43%	43%	48%
56	4.54	2.58	2.51	2.62	2.55	2.60	2.67	2.61	2.50	2.60	2.78
	76%	43%	42%	44%	43%	43%	44%	44%	42%	43%	46%
	4.8	2.6	2.6	2.6	2.6	2.6	2.7	2.6	2.5	2.6	
	79%	44%	43%	44%	43%	43%	45%	43%	42%	43%	

Хамт олны хариуцлагатай байдлыг авч үзвэл ГТУА-х 68-р анги 51%, ГТУА-х 81-р анги 52%, ГТУА-х 56-р анги 50% байгаагаас харвал тус бүрдээ хариуцлагатай байдлыг сайжруулах шаардлагатай байгааг харуулж байна. ГТУА-х ангиудын хувьд анги нь бие биенийхээ амжилтаар бахархдаг байдал 76%-86%, бусад үзүүлэлтүүд 47%-49% байгаа нь хариуцлагатай байдал дээр сайтар анхаарах шаардлагатай байгааг харуулж байна.

Одоо бүлэг хамт олны уур амьсгалыг ерөнхийд нь авч үзье. Үүнийг тодорхойлохдоо бүлгийн нэгдмэл байдлыг хадгалах хүсэл, нягтралын түвшин, харилцааны давтамж, нээлттэй байдал, зохион байгуулалттай байдал, мэдээлэлтэй байдал, хамт олны хариуцлагатай байдлын дунджаар тооцлоо.

Зураг № 6. Бүлэг хамт олны уур амьсгал /хувиар/




ГТУА-х 81-р анги нь бусад ангиудаас харьцангуй өндөр үнэлгээтэй буюу хамт олны уур амьсгал 81% сайн байна. Хамт олны хариуцлагатай байдал ГТУА-х анги тус бүр дээр анхаарах ёстой, сайжруулах үзүүлэлт байна. Үүний дараа бүлгийн нэгдмэл байдлыг хадгалах хүслийг сайжруулах хэрэгтэй. Нээлттэй байдал, зохион байгуулалттай байдал, харилцааны давтамж, мэдээлэлтэй байдал нь бусад үзүүлэлттэй харьцуулбал бага зэрэг өндөр байгаа ч бас л сайжруулах шаардлагатай. Ялангуяа ГТУА-х 68, 56-р ангиуд аль ч үзүүлэлт дээр нэлээдгүй анхаарч, хамт олны уур амьсгалыг сайжруулах сургалт, бусад арга хэмжээг зохион байгуулах хэрэгтэй байна.

Аврагч-гал сөнөөгчийн хөгжүүлэх сургалтыг бүлэг хамт олны уур амьсгалтай холбон сайжруулах арга замыг тодорхойлох: Аврагч-гал сөнөөгчийн хөгжүүлэх сургалтыг байгууллагын жилийн зорилго, зорилтууд, жилийн төлөвлөгөөтэй уялдуулан зохион байгуулахаас гадна тэрхүү ажлын үр дүн тухайн байгууллагын бүлэг хамт олны уур амьсгалд хэрхэн үр дүн үзүүлж байгааг үнэлэн тогтоох шаардлагатай байна.

Тархалтын сургуулилтыг явуулсан хугацааг доорх зурагт харуулав.

Зураг № 7. ГТУА-х 68-р ангийн тархалтын сургуулилтын гүйцэтгэл /минут/



Тархалтын сургуулилт явуулахдаа гал түймэр унтраах нормчлолын дагуу хугацааг бодож гүйцэтгэлтэй харьцуулсан зөрүүг дээрх зурагт харууллаа. Хамт олны уур амьсгалын үзүүлэлт тус бүр нь тус гал түймэр унтраах гүйцэтгэлд хэрхэн нөлөөлж байгаа судлахад хамт олны хариуцлагатай байдал хамгийн их нөлөөлж байна.

ДҮГНЭЛТ

Орхон аймгийн ГТУА-х 68, ГТУА-х 81, ГТУА-х 56-р ангиудын ахлагчийн бүрэлдэхүүний хөгжүүлэх сургалт, бүлэг хамт олны уур амьсгал, тэдний хамаарлыг авч үзлээ.

Онцгой байдлын ерөнхий газрын даргын тушаалаар баталсан сургалтын нэгдсэн төлөвлөгөөний дагуу хууль эрх зүй, бусад сургалтын тэмдэглэлийг хөтлөн ангиуд үйл ажиллагаагаа явуулж байна. Мөн томилгоот ээлжийн албыг гүйцэтгэхдээ салаан захирагч нар ахлагчийн бүрэлдэхүүнд цагийн хуваарийн дагуу сургалтыг орж, мэргэжлийн сурах бичгүүдийг ашиглан, ахлагчийн бүрэлдэхүүнээр тэмдэглэл хөтлүүлэн зохион байгуулж байна.

Бүлэг хамт олны уур амьсгалыг тодорхойлоход ГТУА-х 81-р анги бусад ангиудтай харьцуулахад харьцангуй сайн байлаа. Хамт олны хариуцлагатай байдал ГТУА-х ангиудад 50% байгаа нь цаашид анхаарах хэрэгтэй байгааг харуулж байна.

Албан хаагчийг хөгжүүлэх сургалтад тогтмол, хөтөлбөр төлөвлөгөөтэй хамруулах нь Аврагч-гал сөнөөгчдийн ажлын байран дээр тогтвор суурьшилтай ажиллаж, үүрэг гүйцэтгэл сайжирч багаар ажиллах чадвар нэмэгдэж гал түймэр гамшиг ослоос учирч болох хохирлыг бууруулахад үр нөлөөтэй гэдэг нь хамт олны хариуцлагатай байдал бусад үзүүлэлтийн хувиас харагдаж байна.

Аливаа хөгжүүлэх сургалт нь оролцогчдын сонирхол идэвхийг өрнүүлэхэд чиглэх бөгөөд тэдний сонирхол, мэдлэг чадварыг хөгжүүлэх, хамт олондоо итгэх, ажилдаа сэтгэлээсээ хандах, сурч хөгжихөд тэмүүлэх зэрэг эерэг нөлөө үзүүлдэг ач холбогдолтой.

Анги салбарт зохион байгуулагдаж буй хөгжүүлэх сургалтын гол үр дүн нь бие бүрэлдэхүүний мэргэжлийн мэдлэг, ур чадвар, хөгжил, сахилга, ёс зүйн өндөр чанараар тодорхойлогдоно гэж үзэж байна.

Албан хаагчдыг хөгжүүлэх сургалтууд нь өөрийн албан тушаалын тусгай мэдлэгийг сайжруулах, гүнзгийрүүлэх ажлыг бие даан гүйцэтгэх, мэдлэгээ системтэйгээр сайжруулан гүнзгийрүүлэх, хууль эрх зүйн мэдлэгээ сайжруулах, төрөл бүрийн сургалтын материалын тэмдэглэл хөтлөх, эдийн засаг, гадаад хэл, техникийн болон тусгай мэдлэгийн чиглэлийн шинэ ном сурах бичигтэй тогтмол танилцах, дадал чадвараа бататгах зорилгоор төрөл бүрийн дасгал хийх, гүйцэтгэх гэсэн хэлбэрүүдээр зохион байгуулагдаж байна.

Эдгээр хэлбэрүүдийн хөгжүүлэх сургалтууд нь анги салбарын бие бүрэлдэхүүнд хэрхэн хүрч, хамт олны уур амьсгалд нөлөө үзүүлж байгааг судлан үзэхэд судалгааны таамаглал батлагдаж байна. Өөрөөр хэлбэл, хамт олны уур амьсгалд албан хаагчийн хөгжүүлэх сургалтууд нөлөөлж байна гэж дүгнэхээр байна.

Судалгааны үр дүнгээс албан хаагчдын хөгжүүлэх сургалтыг оновчтой, сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөтэй зохион байгуулснаар бүлэг хамт олны уур амьсгалын шинжүүд болох бүлгийн нэгдмэл байдлыг хадгалах хүсэл, нягтралын түвшин, харилцааны давтамж, нээлттэй байдал, зохион байгуулалттай байдал, мэдээлэлтэй байдал, хамт олны хариуцлагатай байдал гэсэн үзүүлэлтүүдэд нөлөөлж хөгжүүлэх сургалтаар энэхүү шинжүүдийг сайжруулах боломжтой байна гэж дүгнэлээ.

Иймээс цаашид хөгжүүлэх төрлийн сургалтуудыг илүү үр дүнд хүргэхийн тулд мэдээллийн хэрэгсэл, албан болон албан бус уулзалт, судалгаа шинжилгээний үр дүнг ашиглах, олон нийтийн байгууллагуудтай хамтран ажиллах, гадаадын туршлага сургамжийг судалж шинэ арга хэлбэрийг бий болгох, олон нийтийн дунд мэтгэлцээн, хэлэлцүүлэг зохион байгуулах төдийгүй удирдлага зохион байгуулалтын өргөн дэмжлэгийг бий болгох шаардлагатай байна. Анги салбарт хууль, эрхзүйн сургалтыг зохион байгуулж, мэдээллээр хангаж байх шаардлагатай гэж дүгнэв.

НОМ ЗҮЙ

Ном сурах бичиг:

Б.Энхтүвшин. (2020). *Гал түймэр унтраах арга зүйн бодлогын хураамж*.

Улаанбаатар.

Д.Сэржмядаг. (2017, 2018). *Гамшигаас хамгаалах үндэс*. Улаанбаатар:

Соёмбо принтинг.

С.Базаррагчаа. (2018). *Галын техникийн шинжилгээний үндэс*. Улаанбаатар:

Соёмбо принт.

С.Баттөр. (2015). *Аврагч, гал сөнөөгчдийн сэтгэл зүй, бие бялдар, ур чадварын бэлтгэлийн харилцан хамаарал*. Улаанбаатар: Китаб принт.

С.Баттөр, Б.Энхтүвшин, Л.Булганхангай. (2021). *Гал түймэр унтраах үйл ажиллагааны удирдлага*. Улаанбаатар: Галбилэг принт.

Хууль, дүрэм, журам:

Барилга байгууламжийн гал түймрийн эрсдэлийн зэргийн ангилал

Гамшгаас хамгаалах тухай хууль, шинэчилсэн найруулга, 2017

Гал түймэр унтраах дүрэм

Гал түймэр унтраах дасгал сургуулилтын норматив, гүйцэтгэх аргачлал

Монгол улсын төрийн нууцад хамаарах мэдээллийн жагсаалт

Онцгой байдлын албаны сургалтын бодлого

Онцгой байдлын ерөнхий газрын даргын тушаал, гүйцэтгэлийн төлөвлөгөө батлах тухай, 2020

Электрон эх үүсвэр:

сургууль, Д. х. (2023 оны 03 01). <https://www.uia.gov.mn/>.-ээс Гаргасан

<https://www.senecacollege.ca/programs/fulltime/FFP.html>

<https://www.fireengineering.com/leadership/professional-development-in-the-fire-service/#gref>

<https://www.fireservicecollege.ac.uk/training/Course?id=3622>

<https://www.cheshirefire.gov.uk/jobs/wholetime-firefighter-recruitment/training-and-development>

ГАЛ ТҮЙМЭР УНТРААХ, АВРАХ АНГИЙН ДАДЛАГА СУРГУУЛИЛТАД ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭ

ДХИС-ийн магистрант, ахмад Х.Цэнд-Очир

Хураангуй: Гал түймэр унтраах, аврах үйл ажиллагааг зохион байгуулах, бэлтгэл бэлэн байдлыг хангах ажлын үндэс нь дадлага, сургуулилт байдаг. Гал түймэр унтраах аврах, анги гал түймэр унтраах өдөр тутмын, тархалт, тактикийн дадлага сургуулийг хийдэг. Дадлага, сургалтыг зохион байгуулснаар бие бүрэлдэхүүнийг сэтгэл зүй, ур чадвар, бие бялдрын хувьд бэлтгэн дадлагажуулах, багаар ажиллах ажиллагаа, харилцан ойлгох, өндөр ачаалалтай ажиллах, гал түймэр унтраах, аврах ажиллагааг шуурхай зохион байгуулах чадварыг эзэмшдэг. Энэхүү өгүүлэл нь гал түймэр унтраах, аврах ангийн дадлага сургуулилын талаарх бодлого, эрх зүйн зохицуулалтын өнөөгийн байдалд хийсэн шинжилгээ, судалгааны талаар өгүүлэв.

Түлхүүр үгс: Гал түймэр унтраах дасгал сургуулилт

УДИРТГАЛ

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Гамшгийн эрсдэлийг бууруулах газраас Японы Мияги мужийн Сендай хотноо 2015 оны 3 дугаар сарын 14-18-ны өдрүүдэд зохион байгуулсан Гамшгийн эрсдэлийг бууруулах дэлхийн гуравдугаар бага хурлаар гамшгийн эрсдэлийг бууруулах чиглэлээр 2015 оноос 2030 он хүртэл хэрэгжүүлэх Сендайн үйл ажиллагааны хүрээ бодлогын баримт бичиг батлагдсан.

Тус бодлогын баримт бичигт “Гамшгийн эрсдэлийн ойлголт, мэдлэгийг сайжруулах, хөрөнгө оруулалт хийх, гамшгийн эрсдэлийг удирдах засаглал болон бэлэн байдлын чадавхийг бэхжүүлэх, орон нутгийн засаг захиргаа, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх, уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй гамшгийн эрсдэлийг бууруулах” 4 үндсэн чиглэлийг тусгасан билээ.

Дээрх дэвшүүлсэн зорилго, зорилтод нийцүүлэн Монгол улсын Засгийн газраас Сейндайн үйл ажиллагааны хүрээг Монгол Улсад хэрэгжүүлэх дунд хугацааны стратегийг хэрэгжүүлэх арга хэмжээний II үе шат (2021-2025 он)-ны төлөвлөгөө, Онцгой байдлын ерөнхий газрын (2021-2024) онд баримтлах стратеги төлөвлөгөөг боловсруулан баталж хэрэгжүүлэн ажиллаж байна.

Энэхүү төлөвлөгөөнд “Гамшгаас хамгаалах бэлэн байдлыг хангах, гамшгийн дараах сэргээн босгох, нөхөн сэргээх, шинээр барьж байгуулах үйл ажиллагааг урт хугацаанд төлөвлөн хэрэгжүүлэх”⁶¹ зорилтын хүрээнд Онцгой байдлын байгууллагын хүний нөөцийн чадавхыг нэмэгдүүлэх⁶², гал түймэр унтраах, эрэн хайх, аврах ажиллагааны хүч хэрэгслийн чадавхыг нэмэгдүүлнэ⁶³ хэмээн төлөвлөн алслагдсан суурин газруудад гал түймэр унтраах, аврах нэгжийг шинээр байгуулж, Япон, Австри, Хятад, Польш, Беларусь, Франц зэрэг улсуудтай Засгийн газар хоорондын зээл, тусламж, төсөл хөтөлбөрөөр гал түймэр унтраах тусгай зориулалтын автомашинууд гал түймэр унтраах, аврах ангиудад нийлүүлэн

⁶¹ Сендайн үйл ажиллагааны хүрээ бодлогын баримт бичиг

⁶² Сейндайн үйл ажиллагааны хүрээг Монгол Улсад хэрэгжүүлэх дунд хугацааны стратегийг хэрэгжүүлэх арга хэмжээний II үе шат (2021-2025 он)-ны арга хэмжээний төлөвлөгөөний 4.1.1

⁶³ Сейндайн үйл ажиллагааны хүрээг Монгол Улсад хэрэгжүүлэх дунд хугацааны стратегийг хэрэгжүүлэх арга хэмжээний II үе шат (2021-2025 он)-ны арга хэмжээний төлөвлөгөөний 4.1.4